



**“СОЁЛ, СПОРТ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙГ
ОРОЛЦУУЛАХ, ЭРХИЙГ ХАМГААЛАХ” ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Үндэслэл:

Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хүүхдийн эрхийг хамгаалахад төрийн бүх шатны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоог хуульчилсан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 9.1 дүгээр зүйлд соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаа, үйлчилгээн дэх хүүхэд хамгааллын тус тус заасан бөгөөд 9.1.4 дэх хэсэгт Соёл спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж мөрдүүлнэ гэсний дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 дугаар бүхий хамтарсан тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангах.

Зорилго:

“Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах” журмыг хэрэгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, салбар дундын үйл ажиллагааг сайжруулах.

Хамрах хүрээ:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар /Хүүхэд хөгжлийн ордон, Зулзагын гол хүүхдийн зуслан/
- Соёл, урлагийн газрын харьяа байгууллагууд /Номын сан, театр, музей/
- Биеийн тамир, спортын газар
- Спортын мэргэжлийн холбоод, клубүүд

Зохион байгуулагч:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- Соёл, урлагийн газар

Хамтран зохион байгуулагч:

- Биеийн тамир, спортын газар